

Хувьсгалын зүтгэлтнүүдийн нэр болон холбогдох хувьсгалын оныг бичээрэй



Х. Чойбалсан
1921



Т. Намнансүрэн
1911



Д. Бодоо
1921



VIII Богд
1911



М. Ханддорж
1911



С. Зориг 1990



Д. Сүхбаатар
1921



Ж. Батмөнх
1990





С. Данзан
1921



Г. Цэрэнчимэг
1911

Хувьсгалын зүтгэлтнүүдийн нэр болон холбогдох хувьсгалын оныг бичээрэй





Хичээлийн сэдэв:

**XX ЗУУНЫ МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮДИЙН
НАМТАР, ҮЙЛ АЖИЛЛАГАА**



Хичээлийн зорилго

XX зууны хувьсгалын гол удирдагчдын намтрыг судлах замаар тухайн үеийн нийгмийн нөхцөл байдлыг дүгнэх, үнэлэх

Харьцуулах



Түүхчлэн судлах

Үндэслэлтэй тайлбарлах





XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД





XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД




Да лам Г. Цэрэнчимэд

Төрсөн он	1872
Төрсөн газар	Их шавийн нутаг (Төв аймгийн Лүн сум)
Нас барсан он, шалтгаан	1914. Хорлогдсон
Нэр алдар	Үндэсний тусгаар тогтнолын төлөө тэмцэгч, гол удирдагчдын нэг




ХХ ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД




Да лам хааны зарлигийг машид бишрэн, төгөлдөр сэтгэлээр хүлээж авсан боловч өөрт оногдсон үүрэг, хүлээсэн хариуцлагаа ухамсарлах тутам түгшиж байгаагаа “Би бол ухаан нэн ядуу бөгөөд их л айж, сууна” хэмээн илэрхийлж байжээ.

Ж. Болдбаатар “Монгол түмний сод хүмүүс”, УБ., 2013. 235т.



Анх улс төр нээх нь шинэ гэх барихтай адил элдэв хэрэглэх зүйл маш үлэмж бөгөөд санд мөнгө цаасгүйн учир их л чармайж байна. Үлэмжхэн зээлдэж хэрэглэхийг гуйя гэвч эцэст төлөхийг бодох хэрэгтэй тул айх газар бий.

Да лам Цэрэнчимэд



“Хувийн амьдралын хувьд аглаг даяанч, байгалиас заяасан тулх ухаантай, хэнд ч уусаж худалдагдахгүй, хувийн ашиг хонжоо хайдаггүй, хүнд тэр бүр итгэдэггүй, хянуур болгоомжтой... Да лам ... Орчин үеийн Монголын ухаалаг, нэрд гарсан зүтгэлтний нэг нь мөн” хэмээн бичиж байлаа.

1913 онд Оросын “Алс дорно” сэтгүүлд



ХХ ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД

УЛС ТӨРИЙН БАЙР СУУРЬ



“Эелэл тааллыг чухал болгон нөгөө дөрвөн яамыг дотоод яаман бичиг илгээхдээ **“өргөн”** хэмээн мэдүүлж, харин дотоод яамнаас бусад яаманд **“илгээн”** хэмээн бичиж явбаас шүүмжлэл үгүй.

С. Чулуун “Ноёдын үхэл өгүүлэл”



Да лам Оростой харилцахдаа найрсаг бус хоёр нүүр гаргасан бодлого явуулж байна. ... тэр зөвхөн Хятадаас өөрсдийгөө хамгаалууулахаас өөр **бидний ямар ч зөвлөгөөнийг** хүлээн авахгүй байна.

Оросын элчин Н. Крупенский ГЯЯ-ны сайд С. Д. Сазановт илгээсэн захидал



“Тэр бүх Монголчуудыг **эв нэгдэлтэй** байхыг чухалчилдаг, Сүм хийддээ шашны талаар дээгүүр мяндагтай байсан атлаа шашин болон язгууртны дангаар ноёрхох улс төрийн бодлогыг **эсэргүүцэж**, гол гамшиг гэж үзэж байв. Лам нартай тэмцэж байсны учир түүнийг шуламын сүнс гэж нэрлэж байв”.

И. Я. Коростовец.



XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



Д. Бодоо

Төрсөн он	1885
Төрсөн газар	Манзушир хутагтын шавь Дэндэвийн отог. (Төв аймгийн Сэргэлэн сум)
Нэр алдар	1921 оны хувьсгалын гол удирдагчдын нэг, Ардын эрхтэй хэмжээт цаазат Монгол улсын ерөнхий сайд
Нас барсан он, шалтгаан	1922 оны наймдугаар сарын 31. Хилс хэрэг.



XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



Д. Бодоо

- Консулын бүлэг
- Д. Чагдаржав, Х. Чойбалсан, Д. Лосол, С. Жамьян
- М.И. Кучеренко, И.С. Маслоков. В.Я. Гембержевский



С. Данзан

- С.Зүүн хүрээний бүлэг
- Д. Догсом, Ө. Дэндэв, М. Дугажав, Д. Сүхбаатар



ХХ ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



Д. Бодоогоос хүрээний бүлгэмийн нөхдүүдтэй удаа дараа биечлэн уулзаж, зорилго бодлогоо харилцан ойлголцох хэрэгт ихээхэн хүчин чармайлт гаргав.

1920 оны I сарын 05-нд бүлгэмийн 20 гаруй гишүүд сүүгээр хадган дээр бичиж амь биеэ хайрлахгүй, няцалт буцалтгүй тэмцэх тангараг тавьжээ.

Хурал цуглаан хийх, хятад цэргийн үйл ажиллагааг илчилсэн ухуулах хуудас, зохиох, наах, зэвсэг цуглуулан бэлтгэх, Сюу Шүжаны амь насанд халдахыг оролдох гэх мэт

1921 оны 4-р сарын 16-нд Бодоо нь Чагдаржавын оронд Монгол улсын ерөнхий сайд болжээ. 1921 оны 7-р сарын 6-нд Ардын цэрэг Их Хүрээнд орж ирсэн ба 11-нд Ардын эрхт хэмжээт цаазат Монгол улс ба Ардын хувьсгалын ялалтыг зарлан тунхаглахад Бодоо үг хэлсэн байна.



XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД

Анхны цаасан мөнгөн тэмдэгтийг гаргах шийдвэр гаргасан



Анхны хоршоог байгуулах шийдвэр гаргасан



Судар бичгийн хүрээлэн байгуулсан



100 хэрэглэгч холбогддог телефон аппарат ашиглалтад оруулах үүрэг өгсөн



Хүн амын тооллогыг 1922 онд багтаан дуусгах шийдвэр гаргасан



Хэт хээнцэрлэхийг хэмжээлэх шийдвэр

- Эхнэр хүний үсэнд 5 лангаас илүү мөнгө, шүр сувд оруулахыг зогсоох



Богдын даншиг наадамд ирэх төлөөлөгчдийн тоог бууруулах



Богдын уяа морьдын зардлыг хассан



Хуучин засаг ба засаг бус ноёдод Сангийн яамнаас олгодог цол, зэрэг дэвийн мөнгийг хассан



Гадаад өрийг төлөхийг хориглосон






XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



- ❑ 1922 оны 8 сарын 31-нд Догсомын Бодоод **эх орноосоо урвасан хэрэгт хилсээр** ял тулган 15 хүний хамт цаазалжээ.
- ❑ 1997 оны 6 сарын 11-д Улсын Дээд Шүүхийн хяналтын шатны хуралдаанаар Д.Бодоо нарын 15 хүний хэргийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээжээ.





ХХ ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД

БҮХ ЦЭРГИЙН ЗӨВЛӨЛИЙН ГАЗРААС

Ардын Засгийн газар хуудас дагуулан өргөн илгээв,
Явуулахын учир:



... эдүүгээ Бодоогийн зэрэг хүнд ялт арван таван хүнийг цаазаар аваачихад буудан үхүүлсэн зэрэг арван таван хүнд **тусгай шагнал** хүртээх болов уу хэмээн эрмэлзэхийн тулд, үүнд хянавал, урьдахь автономит засгийн үест энэ мэт эрүү барьсан цэрэгт улсын сангаас шан олгож байсан тогтоол буй бөгөөд эдүүгээгийн засгийн үед тусгайлан тогтсон зүйлгүй тул, үүнийг Бүх цэргийн зөвлөлийн газраа өргөн мэдүүлээд олдвол байцаан толилж **эд нарт шагнал олгох эсэх**, хэрэв олгох аваас хүн бүрт хичнээн ямар шагнал олгуулахыг заан тушаах ажаамуу гэх зэрэг эрснийг тус Зөвлөлийн хуралд хянан хэлэлцээд ийнхүү мэдүүлсэн нь зүйтэй учир зүй нь хүн бүрд **арваад төгрөг** шагнавал зохих болов уу хэмээх тул үүнийг Засгийн газраар өргөн илгээгээд олдвол байцаан толилж гүйцэтгэн шийтгэх ажаамуу хэмээн үүний тул өргөн илгээв.



XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



С. Зориг

Төрсөн он	1962.04.20
Боловсрол	Нийслэлийн 23-р дунд сургууль Ломоносовын нэрэмжит Москвагийн Улсын Их Сургуулийн философийн анги
Нэр алдар	Монголын Ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг, улс төрч байв.
Нас барсан он, шалтгаан	1998. 10. 02. Бусдын гарт амиа алдсан.



XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



1998 оны 10 сарын 2-нд Зоригийг гэрт нь олон удаа хутгалж амь насыг нь бүрэлгэв. 3 хоногийн дараа түүнтэй салах ёс гүйцэтгэхээр 30000 хүн цуглаж, эх орон даяар бүх нийтийн гашуудал зарлаж, Монголын ард түмэн хайрт хүүгийнхээ хойноос эмгэнэн гашуудаж байлаа.





XX ЗУУНЫ УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮД



“ Залуусаа? Бид аливаа өдөөн хатгалгад автаж болохгүй, Тайван замын тэмцэл бидний гол зорилго. Ард түмэн биднийг хэн болохыг ширтэн харж байна. Бидэнд ардчилал, тэсвэр тэвчээр хэрэгтэй. Ардчиллыг дэмжиж байгаа бол дороо зайгаа барин арагшаа болцгоо. ... За одоо урд талын эгнээнийхэн сууцгаа. Арынхан нь ... ”



XX ЗУУНЫ МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ЗҮТГЭЛТНҮҮДИЙН НАМТАР, ҮЙЛ АЖИЛЛАГАА



1872-1914



1885-1922



1962-1998





ГЭРИЙН ДААЛГАВАР



Даалгаврын
хувилбарууд

XX зууны түүхэн зүтгэлтнүүдээс сонгон авч
судлаарай.


Бүтээлч даалгавар хийж, танилцуулах

- Оюуны зураглал
 - Контент бэлтгэх
-

2-3 Сурвалж тайлбарлах, дүгнэх



АНХААРАН СОНССОНД БАЯРЛАЛАА

Би монгол хүний саруул ухаанд итгэдэг.  С.Зориг